



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 4/04

Улаанбаатар хот

Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7¹ дүгээр зүйлийн 7^{1.5} дахь заалт, Дүүргийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хамтран ажиллах санамж бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй хүүхэд хамгаалал ба нөлөөлөл, өрхийн амьжиргаа, орон нутгийн хөгжлийн урт хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Төсөлд хамрагдах иргэдийн мэдээлэл, судалгааг гарган үйл ажиллагааг зохион байгуулан ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (С.Мөнхзаяа)-т үүрэг болгосугай.


3. Дэлхийн зөн монгол Олон Улсын байгууллагын төслийн хэрэгжилтийг хангаж Засаг даргад тухай бүр тайлагнан ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан төслийн удирдагч (Д.Жаргалсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР

Баянгол дүүргийн Засаг даргын
2022 оны 01 дүгээр сарын 07-ний өдрийн
.../04... дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан төслийн удирдагч

Гишүүд:

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Боловсролын хэлтсийн дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга

Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн дарга

Гэр бүл, хүүхэд залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн

Дэлхийн Зөн Монгол Олон улсын хөтөлбөрийн

Хамтын ажиллагааны багийн ахлагч

Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Баянгол орон нутгийн хөтөлбөрийн менежер

Нарийн бичиг:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн